МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2019 2-Р САР

Э-сонин

67-р дугаар

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

Үнэт цаасны зах зээл

Зах зээлийн тойм

/2019.02.28-ны өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	**17**
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	**13,352,114,074.92**
Хувьцаа /анхдагч/	10,000,000,000
Хувьцаа /хоёрдогч/	1,744,933,534.92
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	1,607,180,540
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	**55,654,111**
Хувьцаа /анхдагч/	50,000,000
Хувьцаа /хоёрдогч/	5,638,393
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	15,718
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	**6,774**

Зах зээлийн үнэлгээ



TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1.Нийт компанийн тоо	**216**
100% төрийн өмчит	18
Төрийн өмчийн оролцоотой	11
Хувийн өмчийн	187
I ангилал	13
II ангилал	42
III ангилал	167

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо		**61**
Үүнээс:	*Брокер, Дилер*	52
	Андеррайтер	24
	Хөрөнгө оруулалтын зөвлөх	13

Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2019.02.28-ны байдлаар/

Симбол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Голомт Капитал ХХК	42,496,149	8,754,411,157	50,397,840	10,192,031,894	18,946,443,051
2	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	895,662	919,680,885	1,266,165	1,278,551,243	2,198,232,127
3	БиДиСек ХК	2,934,818	831,067,621	1,488,115	847,231,434	1,678,299,054
4	Ти Ди Би Капитал ХХК	1,713,357	412,693,085	436,842	139,913,850	552,606,936
5	Ард секюритиз ХХК	1,307,299	353,973,690	391,767	183,555,306	537,528,996
6	Стандарт инвестмент ХХК	1,553,154	363,505,009	194,137	75,379,912	438,884,921
7	Тэнгэр капитал ХХК	118,786	389,173,290	22,003	2,254,165	391,427,455
8	Бумбат-Алтай ХХК	618,425	231,663,115	204,871	96,962,472	328,625,588
9	Новел инвестмент ХХК	406,417	115,989,512	374,269	116,290,978	232,280,490
10	Ард капитал групп ХХК	465,304	111,312,880	149,683	107,783,143	219,096,022
11	Гаули ХХК	642,448	135,625,579	126,404	41,945,888	177,571,467
12	Эм Ай Би Жи ХХК	28,410	85,934,541	14,076	28,868,395	114,802,936
13	Батс ХХК	460,135	95,687,387	11,268	4,751,200	100,438,587
14	Таван богд ХХК	10,990	28,830,495	31,300	35,644,845	64,475,340
15	Апекс Капитал ҮЦК	97,597	43,367,716	58,199	17,884,506	61,252,221
16	Централ секьюритийз ҮЦК	98,364	48,878,151	23,249	4,922,515	53,800,666
17	Блүмсбюри секюритиес ХХК	14,930	6,273,791	64,654	45,620,701	51,894,492
18	Зэргэд ХХК	174,954	33,169,257	35,328	10,676,342	43,845,598
19	Монсек ХХК	127,743	25,011,396	127,541	18,797,473	43,808,869
20	Гүүдсек ХХК	189,245	39,695,566	7,268	2,842,113	42,537,679

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2019.02.28-ны байдлаар/

№	Сим-бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт /% /
1	APU	АПУ	814,073	510,046,337	700	592	5.00	666.87
2	GOV	ГОВЬ	982029	326,544,620	348	315	-1.95	253.34
3	TTL	ТАВАН ТОЛГОЙ	40,879	279,011,980	7,550	6,000	1.79	375.24
4	AIC	АРД ДААТГАЛ	303838	213582760	734	685	-0.18	17.47
5	MND	МАНДАЛ ДААТГАЛ	35,602	186,644,726	5,695	4,950	-0.98	31.53
6	TUM	ТҮМЭН ШУВУУТ	642,177	132,119,505	220	199	-0.14	39.94
7	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	1798820	126,562,866	75	67	-8.50	54.44
8	TCK	ТАЛХ ЧИХЭР	5491	89,191,900	21,980	16,060	5.26	20.47
9	ADU	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	39,014	34,912,493	945	850	8.30	14.48
10	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	68,969	33,956,229	520	455	9.89	18.40
11	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	58074	31672196.5	600	531	-10.17	53.67
12	MBW	МОНГОЛ БАЗАЛЬТ ХК	123,202	31,328,579	270	241	-6.86	14.10
13	BDS	БИ ДИ СЕК	34,813	30,048,876	970	810	-8.95	14.08
14	TAH	ТАХЬ-КО	2,112	25,455,120	12,060	10,500	-1.15	14.35
15	ERDN	ӨРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЭЙШН ХК	45163	24138014.7	589	513	-0.06	2.08
16	SUU	СҮҮ	107,693	22,463,705	217	202	2.85	71.78
17	ITLS	АЙТҮҮЛС	209,757	20,670,560	105	91	-3.85	3.45
18	MIE	МАТЕРИАЛИМПЕКС	1,720	13,766,500	8,100	8,000	0.00	10.95
19	SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	83	10,764,000	140,000	124,000	25.82	9.05
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	227	6953000	34200	28000	21.00	14.38

Ханшийн өсөлттэй хувьцаа

/2019.02.28-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт /%/
			2019-02-01	2019-02-28		
1	БАЯНТЭЭГ	98	18,280.00	27,400.00	9,120.00	49.89
2	ЭРЧИМ БАЯН ӨЛГИЙ	2	650.00	820.00	170.00	26.15
3	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	83	110,000.00	138,400.00	28,400.00	25.82
4	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	227	28,100.00	34,000.00	5,900.00	21.00
5	МОНГОЛ ДИЗЕЛЬ	1	357.07	410.63	53.56	15.00
6	ОРХОН ХӨГЖИЛ	3	285.92	328.80	42.88	15.00
7	ХҮРД	37	2,128.00	2,447.00	319.00	14.99
8	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	17	917.87	1,051.00	133.13	14.50
9	МОГОЙН ГОЛ	211	7,000.00	7,900.00	900.00	12.86
10	РЕМИКОН	222,372	27.07	30.10	3.03	11.19
11	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	68,969	455.00	500.00	45.00	9.89
12	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	39,014	850.00	920.51	70.51	8.30
13	ТАЛХ ЧИХЭР	5,491	19,000.00	20,000.00	1,000.00	5.26
14	АПУ	814,073	596.81	626.65	29.84	5.00
15	ДАРХАН НЭХИЙ	93	16,010.00	16,500.00	490.00	3.06
16	МОНГОЛ ШИЛТГЭЭН	54	388.33	400.00	11.67	3.01
17	СҮҮ	107,693	202.87	208.66	5.79	2.85
18	МАХИМПЕКС	1,002	2,550.00	2,620.00	70.00	2.75
19	ШИВЭЭ ОВОО	362	2,000.00	2,042.00	42.00	2.10
20	МЕРЕКС	6,960	24.00	24.50	0.50	2.08

Ханшийн бууралттай хувьцаа

/2019.02.28-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2019-02-01	2019-02-28		
1	АДУУН ЧУЛУУН	539	2,100.00	1,550.00	-550.00	-26.19
2	БӨӨНИЙ ХУДАЛДАА	208	390.00	300.00	-90.00	-23.08
3	БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	10	1,200.00	1,025.00	-175.00	-14.58
4	МОНГОЛ НЭХМЭЛ	25	2,100.00	1,801.00	-299.00	-14.24
5	ХЭРЛЭН ХИВС	300	101.20	87.00	-14.20	-14.03
6	МИК ХОЛДИНГ	2	14,750.00	12,800.00	-1,950.00	-13.22
7	ХӨХ ГАН	24,642	80.00	70.00	-10.00	-12.50
8	УБ-БҮК	2,329	385.00	340.00	-45.00	-11.69
9	МОНГОЛ ШУУДАН	58,074	600.00	538.97	-61.03	-10.17
10	НАКО ТҮЛШ	485	110.00	100.00	-10.00	-9.09
11	БИ ДИ СЕК	34,813	910.00	828.51	-81.49	-8.95
12	ЛЭНДМН ББСБ ХК	1,798,820	74.37	68.05	-6.32	-8.50
13	ЖИНСТ-УВС	3,903	1,850.00	1,700.00	-150.00	-8.11
14	МОНГОЛ БАЗАЛЬТ	123,202	268.40	250.00	-18.40	-6.86
15	МОНГОЛ ШЕВРО	42	2,580.00	2,430.00	-150.00	-5.81

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ТӨХК 2018 ОНД

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь 2018 онд нийт 252 удаагийн арилжаа зохион байгуулж, хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 136 компанийн 666.8 сая ширхэг хувьцааг 210.0 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 332.8 мянган ширхэг үнэт цаасыг 33.5 тэрбум төгрөгөөр, компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 6.3 мянган ширхэг бондыг 631.6 сая төгрөгөөр тус тус арилжиж, нийт 244.1 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна.

Тайлант хугацааны голлох үйл явдлууд, өөрчлөлтүүдийг дурдвал:

- МХБ нь үүсгэн байгуулагдсанаас хойшхи түүхэндээ жилд хамгийн олон буюу нийт 5 шинэ, 2 нэмэлт үнэт цаасыг бүртгэж, анхдагч зах зээлд нийт 31.4 тэрбум төгрөгийн арилжаа хийв;
- Канад улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" нь Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа бүртгүүлснээр үнэт цаасны давхар бүртгэл хөрөнгийн зах зээлд нэвтэрсэн;
- МХБ-ийн үйл ажиллагааны үндсэн журмууд болох "Арилжааны журам", "Үнэт цаасны бүртгэлийн журам", "Үнэт цаасны үнийн индекс тооцох журам", "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам", "Гишүүнчлэлийн журам"-ууд шинэчлэн батлагдсан;
- ЗГҮЦ-ны арилжаа 2015-2017 онуудад нийт арилжааны үнийн дүнгийн 85-95 орчим хувийг эзэлдэг байсан бол 2018 онд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа огт явагдаагүйн улмаас энэ нь нийт арилжааны дөнгөж 13.7 хувийг бүрдүүлсэн байна;
- МХБ нь тайлант хугацаанд Улсын төсвөөс ямар нэгэн санхүүжилт авалгүйгээр хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн аюулгүй, найдвартай, хэвийн ажиллагааг хангаж ажиллахад 838.9 сая төгрөгийг компанийн өөрийн эх үүсвэрээс төлж, шийдвэрлэн санхүүгийн хувьд Улсын төсвөөс хараат бус байдалд шилжлээ.

Санхүүгийн үзүүлэлтийн хувьд 2017 онтой харьцуулахад хувьцааны арилжаа 2.7 дахин нэмэгдсэн хэдий ч Засгийн газрын үнэт цаасны арилжаа 739 тэрбум төгрөгөөр буурснаар компанийн үйл ажиллагааны нийт орлого 1.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 6.95 хувиар буурсан үзүүлэлттэй, нийт үйл ажиллагааны зардлын дүн 2.6 тэрбум төгрөгт хүрч, 805.1 сая төгрөгийн татварын өмнөх алдагдлыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд Улсын төсөвт нийт 362.4 сая төгрөгийн татвар, шимтгэлийг төлсөн байна.

ЛОНДОНГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД ЗОЧИЛЛОО

2019 оны 2-р сарын 22-ны өдөр Лондонгийн хөрөнгийн биржийн Гүйцэтгэх Захирал Ноён Нихил Рати, Лондонгийн хөрөнгийн бирж группийн Европын бүсийн Анхдагч зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан захирал Хатагтай Аюуна Нечаева, ИБУИНВУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ноён Филипп Малоне нар Монголын хөрөнгийн биржид зочилж, 5916 удаагийн арилжааг нээж цан цохилоо.

Тус уулзалтын үеэр МХБ болон ЛХБ-ийн хамтын ажиллагаа сүүлийн 8 жилийн хугацаанд үр дүнтэй хэрэгжиж, томоохон ахиц дэвшлүүд гарсныг дурдаад, цаашид Лондонгийн болон Монголын хөрөнгийн зах зээлд давхар бүртгэл хийх замаар шинэ бүтээгдэхүүнүүд бий болгох, зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулах, Монголын хөрөнгийн зах зээлийг Лондон дахь хөрөнгө оруулагчдад сурталчлах, дотоодын мэргэжлийн боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх зэрэг олон чиглэлээр үргэлжлүүлэн хамтран ажиллах сонирхолтой байгаагаа хоёр талаас илэрхийллээ.

Монголын хөрөнгийн бирж нь Лондонгийн хөрөнгийн биржтэй 2011 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр Ажлын мастер гэрээ байгуулж, хамтын ажиллагаагаа эхлүүлж байсан бөгөөд тус гэрээний хүрээнд хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчныг сайжруулах, шинэ техник, технологи суурилуулах, МХБ-ийн зохистой бүтэц, засаглалыг бий болгох, дотоодын мэргэжилтнүүдийг чадавхижуулах гэсэн үндсэн зорилтуудын хүрээнд шат дараалсан үйл ажиллагаануудыг амжилттай хэрэгжүүлж, дорвитой үр дүнд хүрсэн билээ.

Тухайлбал, хууль эрх зүйн орчны шинэчлэлийн ажлын хүрээнд МХБ нь ЛХБ-тэй хамтран "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль", "Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль"-ийг шинэчлэн боловсруулах ажилд идэвхтэй оролцсон нь олон улсын практикт хэрэглэгддэг кастодианы үйл ажиллагаа, үнэт цаасны давхар бүртгэл, номинал дансны бүтэц, төлбөр тооцооны Т+3 систем, хадгаламжийн бичиг зэрэг дотоодын хөрөнгийн зах зээлд дутагдаад байсан ойлголт, зохицуулалтуудыг шинээр бий болгосон билээ. Түүнчлэн, МХБ-ийн үйл ажиллагаатай холбоотой 10 гаруй дүрэм, журмыг шинэчлэх ажлыг хэрэгжүүлснээр манай дотоодын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтууд олон улсын жишигт нийцсэн болно.

Зах зээлд шинэ техник технологи нэвтрүүлэх зорилгоор дэлхийн 20 гаруй улсын 30 орчим хөрөнгийн бирж, санхүүгийн байгууллагуудад ашиглагддаг "Миллениум Ай Ти" цогц системийг нэвтрүүлсэн нь үнэт цаасны арилжаа технологийн хамгийн өндөр түвшний аюулгүй байдлыг хангах, хөрөнгө оруулагчдад ханшийн бодит цагийн мэдээлэл хүргэх, зохицуулах байгууллагын зүгээс арилжаанд бодит цагийн хяналт тавих, үнэт цаасны компаниуд төдийгүй хөрөнгө оруулагчид зайнаас онлайнаар арилжаанд оролцох, ахисан түвшний функц, захиалгын төрлүүд, дуудлага арилжааны горим, багцын арилжаа зэргийг ашиглах боломжийг бий болгосноор үнэт цаасны арилжааг шинэ түвшинд гаргаж хөгжүүлсэн билээ.

Түүнчлэн, Лондонгийн хөрөнгийн биржийн Академийн сургалтанд дотоодын зах зээлийн 120 гаруй мэргэжилтнийг хамруулсны зэрэгцээ тус биржийн зөвлөх мэргэжилтнүүд МХБ-д томилогдон ажиллахдаа дотоодын зах зээлд ажиллаж буй мэргэжилтнүүдийн мэдлэг, чадварыг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулсан нь өнөөг хүртэл өгөөжөө өгч байна.

Цаашид, зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дотоодын зах зээлийг олон улсын хөрөнгө оруулагчдад сурталчлах, өмч хувьчлалыг хэрэгжүүлэх, дотоодын компаниудад хөрөнгө босгоход туслалцаа үзүүлэх, зах зээлийн чадавхийг бэхжүүлэхэд Лондонгийн хөрөнгийн биржийн байр суурь, оролцоо чухал болохыг талууд онцлон тэмдэглэв.

Э-Сонин *67-р дугаар*

"АРД КРЕДИТ ББСБ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБОГДУУЛАН ЦАН ЦОХИХ ЁСЛОЛ БОЛЛОО

Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн “Ард Кредит ББСБ” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлсэнтэй холбогдуулан цан цохих ёслолын үйл ажиллагаа өнөөдөр боллоо. Энэхүү арга хэмжээнд Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Лхагвасүрэн, Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг, “Ард Кредит ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганзориг, "Ард кредит ББСБ" ХК-ийн хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүн С.Гэрэлтуяа, "Ард капитал групп" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нар оролцож, Монголын хөрөнгийн биржийн 5,912 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.

"Ард кредит ББСБ" ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан, "Ард санхүүгийн нэгдэл" ХК-ийн хөрөнгө оруулалттай компани бөгөөд зээл олгох, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга зэрэг үйлчилгээг эрхэлдэг. Тус компани нь зээлийн бүтээгдэхүүнийг санхүүжүүлэх зорилгоор нийт хувьцааныхаа 25 хувь буюу 70,000,000 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 70 төгрөг ба түүнээс доошгүй (70-85 төгрөг) төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаалж, нийт 4.9 тэрбум төгрөг ба түүнээс доошгүй хэмжээний хөрөнгийг төгрөгийг татан төвлөрүүлэхээр ажиллаж байна. Үнэт цаасны худалдан авах захиалгыг 2019 оны 2 дугаар сарын 18-наас 2019 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 10:00-15:00 цагийн хооронд Монголын хөрөнгийн биржийн бүх гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан хүлээн авах юм.

БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН АНХААРАЛД

Санхүүгийн зохицуулах хорооноос Компанийн тухай хуулийн дагуу **“Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”**-ыг мөрдүүлдэг. Хуульд хувьцаат компани (ХК)-ууд Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)-аа санхүүгийн жил дуусанаас хойш дөрвөн сарын дотор буюу дөрөвдүгээр сарын 30-наас өмнө зарлан хуралдуулахаар заасан. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) ХЭХ-ыг хуралдуулах тухай шийдвэрээ уг хурал болох өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө гаргах бөгөөд шийдвэрийг гурав хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдлээр ирүүлнэ. Шийдвэр гарснаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хуулиар хориглодог.

Дээр дурдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-аар хурал хуралдуулахтай холбоотой үйл ажиллагааг цаг хугацаатай нь нарийвчлан журамласан. Тухайлбал, энэ сарын 19-ны дотор хувьцаат компаниудын ТУЗ ногдол ашиг олгохтой холбоотой шийдвэрээ гаргаж баталгаажуулах учиртай. Улмаар ирэх сарын 21-ний дотор ХЭХ-ыг хуралдуулах тухай шийдвэрээ гаргаж, 24-ны дотор Хороонд мэдэгдэнэ. Ингээд гуравдугаар сарын 26-ны дотор ХЭХ-ын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд зарлаж, 31-ний дотор үнэт цаасны компани (ҮЦК)-уудад хүргэдэг. ХЭХ хуралдуулах тухай энэхүү зарыг дөрөвдүгээр сарын 10-ны дотор дахин олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх бөгөөд ингэхдээ анхны мэдээлсэн хэлбэр, агуулгыг өөрчлөхгүй.

ХЭХ-ын зарыг нийтэд мэдээлснээс 15-20 дахь хоногт буюу дөрөвдүгээр сарын 15-ны дотор хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэж нэрсийн жагсаалт гаргах бөгөөд бүртгэлийн өдрийг ТУЗ хурлын шийдвэрийг гаргахдаа тогтоосон байна. Ингээд Компанийн тухай хуульд заасан хугацаанд буюу дөрөвдүгээр сарын 30-ны дотор хуралдуулж, хурлын шийдвэрийг хурал хуралдсанаас хойш 3 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

"ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛИЙН АНГИЛАЛ АХИУЛЛАА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 20 дугаар зүйлийн 20.2, 20.3.6 дахь заалтууд болон "Лэндмн ББСБ" ХК-ийн 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 1/153 тоот албан бичгээр ирүүлсэн ангилал ахиулах тухай хүсэлт зэргийг тус тус үндэслэн "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 2 дугаар сарын 28-ний өдрийн А/19 тоот тушаалаар "Лэнд МН ББСБ" ХК-ийн үнэт цаасыг "II" ангиллаас ахиулан "I" ангилалд бүртгэлээ.

БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН АНХААРАЛД

"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" (TSX: ERD | MSE: ERDN) нь Монгол улсын баруун өмнөд хэсэг т орших өөрийн 100% эзэмшлийн Хөндий алтны төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг Канад улсын цахим тайлан мэдээний SEDAR системд нийтэлсэн байна.

Тус анхан шатны эдийн засгийн тооцооллоор 8 жилийн хугацаанд жилд дунджаар 3.42 г/т дундаж алтны агуулга бүхий 51,200 унц алт олборлох, өдөрт 1800 тонн хүдрийг баяжуулан боловсруулахаар тус тус төлөвлөсөн бөгөөд дараах голлох үзүүлэлтүүдийг гаргасан байна. Үүнд:

- Алтны үнийг $1,200/унц-аар төсөөлөн тооцоход татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэнэ (5% хоргодуулалтаар) $99 сая ам.доллар, өгөөжийн дотоод хувь (“IRR”) нь 56%;
- Алтны үнийг $1,300/унц-аар төсөөлөн тооцоход татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэнэ (5% хоргодуулалтаар) $124 сая ам.доллар, өгөөжийн дотоод хувь (“IRR”) нь 68%;
- Төслийн анхан шатны хөрөнгө оруулалт 32 сая ам.доллар;
- Нэг унц алт үйлдвэрлэх зардал (“AISC”) нь $714 ам.доллар;
- Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа: 2 жил

"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЭЙШН" НЬ ХААЛТТАЙ ХҮРЭЭНД НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАНА

Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд бүртгэлтэй, Монгол Улсад хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" (T SX: ERD | MSE: ERDN) нь Торонтогийн хөрөнгийн биржид 7,608,696 ширхэг үнэт цаасыг нэмэлтээр бүртгүүлж, нэг бүрийг нь 0.23 кан.доллараар хаалттай хүрээнд санал болгон худалдаж, нийт 1,750,000 кан.долларын хөрөнгө оруулалтыг татахаар төлөвлөж байгаа тухай мэдэгдлээ.

Тус компани нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг Хөндий Алтны Төслийн Урьдчилсан Техник Эдийн Засгийн Үндэслэлийг боловсруулах, ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргах, Монгол Улсын Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамнаас олгож эхэлсэн тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад оролцох, компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зэрэг үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөж байна.

"МОНГОЛ БАЗАЛЬТ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР ШИЙДВЭРЛЭЛЭЭ

МХБ-ийн үнэт цаасны III ангилалд бүртгэлтэй "Монгол базальт" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн №02 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нийт 56.4 сая төгрөг буюу нэгж хувьцаанд 1 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийг ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоох бөгөөд ногдол ашгийг компанийн мөнгөн урсгалын нөхцөлийг харгалзан 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд "ҮЦТХТ" ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар болсон байна.

"ГОВЬ" ХК НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХААР ШИЙДВЭРЛЭЛЭЭ

"Говь" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн №2 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 6.8 /татварын өмнөх дүн/ төгрөг буюу нийт 5,304,765,000 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгож гаргана. Ногдол ашгийг 2019 оны 4 сарын 25-ны өдрөөс эхлэн компанийн байранд бэлэн мөнгөөр эсвэл хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу харилцах дансанд нь шилжүүлэх зэргээр чирэгдэл багатай арга хэлбэрээр саадгүй олгох бөгөөд 2019 оны эцэст ногдол ашгийн үлдэгдэл тооцоог гарган "ҮЦТХТ" ХХК-д байрших хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэхээр болсон байна.

"БАЯН ТЭЭГ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Баянтээг" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн №04 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 3958.7 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож, 2019 оны 6 дугаар сарын 01-ний өдөрт багтаан "ҮЦТХТ" ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

"ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Хөвсгөл Алтан Дуулга" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн №02 тоот тогтоолоор компанийн хуримтлагдсан цэвэр ашгаас нэгж хувьцаанд 120 төгрөг буюу нийт 1.88 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож, 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн компанийн байранд мөнгөн хэлбэрээр олгохоор шийдвэрлэсэн байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА

Монголын хөрөнгийн биржид бүртгэгдэн олон нийтэд арилжаалагдсан Засгийн газрын үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдсөн тухай "Арилжааны төлбөр тооцооны төв" ТӨХХК-аас ирүүлсэн албан тоотуудыг үндэслэн 1170 кодтой, ЗГЭБ-У-158-348 төрлийн 5 ширхэг, 1224 кодтой, ЗГЭБ-У-104-402 төрлийн 10200 ширхэг, 1176 кодтой ЗГЭБ-У-354 төрлийн, 610 ширхэг үнэт цааснуудыг биржийн бүртгэлээс тус тус хаслаа.

"ТАЛХ ЧИХЭР" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Талх Чихэр" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн №02 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 200 төгрөг буюу нийт 204.7 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож, 2019 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн компанийн байранд мөнгөн хэлбэрээр олгохоор шийдвэрлэсэн байна.

“МАХ ИМПЕКС" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

“Мах Импекс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн №01 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 120 төгрөг буюу нийт 456 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож, 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн компанийн байранд мөнгөн хэлбэрээр олгохоор шийдвэрлэсэн байна.

“МОНГОЛ ШУУДАН" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

“Монгол Шуудан” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн №19/01 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 4.7 төгрөг буюу нийт 468 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож, 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн "ҮЦТХТ" ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

“ХҮРД" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

“Хүрд” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн №04 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 550 төгрөг буюу нийт 74.4 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож, 2019 оны 2-р улиралд багтаан компанийн байранд тарааж үлдсэн мөнгийг "ҮЦТХТ" ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

“АПУ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

“АПУ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн №19/02 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 46 төгрөг буюу нийт 48.9 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож, 2019 оны 12-р сарын 31-ны өдрийн дотор багтаан "ҮЦТХТ" ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

“АРД ДААТГАЛ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Ард Даатгал" ХК- ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн №2/19 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 25.27 төгрөг буюу нийт 631.7 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны 3-р сарын 15-ны өдрөөр тогтоож, 2019 оны 6-р сарын 29-ны өдрийн дотор багтаан "ҮЦТХТ" ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

“МАНДАЛ ДААТГАЛ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Мандал Даатгал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн №19/001 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 100 төгрөг буюу нийт 624.3 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож, 2019 оны 5-р сарын 01-ны өдрөөс 5-р сарын 31-ний өдрийн хооронд багтаан "ҮЦТХТ" ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Жуулчин Дюти Фрий" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн №03/02 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 10,000 төгрөг буюу нийт 653.6 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож, 2019 оны 5-р сарын 31-ны өдрөөс эхлэн компанийн байранд мөнгөн хэлбэрээр олгохоор шийдвэрлэсэн байна.

“ГУТАЛ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Гутал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн №Б-03 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 777 төгрөг буюу нийт 1.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны 3-р сарын 13-ны өдрөөр тогтоож, 2019 оны 5-р сарын 06-ны өдрөөс эхлэн Баасан гараг бүр "Гутал" ХК-ийн байранд олгохоор шийдвэрлэсэн байна.

“УБ БҮК" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"УБ БҮК" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн №2019/02тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1 төгрөг буюу нийт 131.5 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож, 2019 оны 6-р сарын 01-ний өдрөөс эхлэн "ҮЦТХТ" ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

“ТЕХНИК ИМПОРТ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Техник импорт" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн №1 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 500 төгрөг буюу нийт 723.3 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны 3-р сарын 11-ний өдрөөр тасалбар болгож 2019 оны 4-р сарын 11-ний өдрөөс эхлэн компанийн байранд олгохоор шийдвэрлэсэн байна.

“УЛААНБААТАР ХИВС" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Улаанбаатар Хивс" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн №01/2019 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 120 төгрөг буюу нийт 48.5 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2019 оны 3-р сарын 18-ны өдрөөр тогтоож, 2019 оны 5-р сард багтаан "ҮЦТХТ" ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

ЗАРИМ КОМПАНИУДЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖИЛИЙН ХУРААМЖИЙГ ХӨНГӨЛЛӨӨ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83.1 зүйл, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Дүрмийн 8.10.11 заалт, Гишүүнчлэлийн журмын 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн гаргасан Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын А/19 тоот тушаалын дагуу 2018 онд хийгдсэн арилжааны үнийн дүнгээр тэргүүлэн, МХБ-ийн нийт арилжааны үнийн дүнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх хэмжээний гүйлгээг хийсэн дараах нэр бүхий 6 гишүүн үнэт цаасны компанийг 2019 оны гишүүнчлэлийн жилийн хураамжаас тус бүр 10 хувийн хөнгөлөлт эдлүүлэхээр боллоо.

	Гишүүн ҮЦК-ийн нэрс	Нийт арилжааны үнийн дүн	Эзлэх хувь
1	"Голомт Капитал ҮЦК" ХХК	194,959,607,638	39.90%
2	"Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК	71,583,559,504	14.70%
3	"Мирэ Эссэт Секьюритис Монгол ҮЦК" ХХК	58,233,086,525	11.90%
4	"Би Ди Сек ҮЦК" ХК	39,510,233,868	8.10%
5	"Новел инвестмент ҮЦК" ХХК	28,210,906,685	5.80%
6	"Бумбат-Алтай ҮЦК" ХХК	24,578,030,928	5.00%

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН

Монгол Улс, Улаанбаатар хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж

+976 11-313747

+976 11-325170

Info@mse.mn

WWW.MSE.MN